223001	Бусад хөрөнгө	144,208,600.00	140,616,772.00	3,591,828.00	97.51
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	45,000,000.00	-	45,000,000.00	-
230001	Эргэж төлөгдөх зээл	45,000,000.00	-	45,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,016,856,400.00	2,006,522,849.18	10,333,550.82	99.49
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,261,634,200.00	1,251,842,222.00	9,791,978.00	99.22
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,132,425,600.00	1,122,633,635.00	9,791,965.00	99.14
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	129,208,600.00	129,208,587.00	13.00	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	682,473,000.00	666,987,223.18	15,485,776.82	97.73
132001	Орон нутгийн төсвөөс	682,473,000.00	666,987,223.18	15,485,776.82	97.73

Давст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,349,200.00	9,205,876.00	2,143,324.00	81.11
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,349,200.00	9,205,876.00	2,143,324.00	81.11
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	61,400,000.00	78,487,528.00	-17,087,528.00	127.83
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000,000.00	78,487,528.00	-38,487,528.00	196.22
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	21,400,000.00	-	21,400,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,656,863.60	-25,656,863.60	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	98,688,928.40	-98,688,928.40	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	536.00	536.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	101.00	101.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	11.00	11.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	59.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	11.00	11.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	328.00	328.00	-	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	203.00	203.00	-	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	203.00	203.00	-	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	125.00	125.00	-	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	125.00	125.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	101.00	101.00	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	30.00	30.00	-	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00	-	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.00	17.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	27.00	27.00	-	100.00
650010	Гэрээт ажилтан	7.00	7.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	-	100.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		252,269,657.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		252,269,657.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		193,442,657.00
210101	Үндсэн цалин		45,644,961.00
210102	Нэмэгдэл		32,672,817.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-
210104	Урамшуулал		12,972,144.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
210201	Тэтгэврийн даатгал		14,737,824.00
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан		1,088,240.00
210302	Түлш, халаалт		-
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал		
210401	Бичиг хэрэг		15,584,156.00
210402	Тээвэр, шатахуун		-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		5,453,856.00
210404	Ном, хэвлэл		430,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,530,000.00
2105	Нормативт зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		8,170,300.00
210502	Хоол, хүнс		84,467,470.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		70,862,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	15,189,993.00
210602	Тавилга		8,289,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		-

Давст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар		6.900.193.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	925.000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		925.000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	15.805.013.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		14.448.500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1.356.513.00
211	ХҮҮ	0.00	-
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	-
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр		
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	0.00	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		
212	ТАТААС	0.00	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.00	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	58.827.000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	57.910.000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		57.910.000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	917.000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		917.000.00

Давст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		-
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	-
230001	Эргэж төлөгдөх зээл		
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	252,302,927.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	252,302,927.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		29,100,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		221,952,927.00
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		33,270.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		33,270.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Давст сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхмандал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Давст сумын Засаг дарга нь “Гэр бүл төвтэй, бүтээлч, оюунлаг иргэдийнхээ эрүүл аюулгүйн орчинд амвдрах боломжийг бүрдүүлж байгаль экологид ээлтэй, дэвшилтэт технологид суурилсан зохистой хэрэглээ, аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж, ухаалаг засаглал, тогтвортой хөгжил бүхий өрсөлдөх чадвараар тэргүүлэх сум болно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх
- Байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
- Орон нутагт дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах
- Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Давст сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 30.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,032.3 сая төгрөгийн 2 хувь буюу 60.6 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 48.5 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Давст сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,528.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	/сая.төгрөг/ Өөрчлөлт 3=2-1
			Мөнгөн хөрөнгө
Авлага	233.0	227.2	-5.8
Урьдчилгаа			
Бараа материал	225.5	291.2	65.7
Үндсэн хөрөнгө	5,035.5	7,381.2	2,345.7
Нийт хөрөнгө	5,557.9	8,086.2	2,528.3
Өр төлбөр	42.4	11.1	-31.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,515.5	8,075.1	2,559.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,557.9	8,086.2	2,528.3

Эх сурвалж: Давст сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 186.5 сая төгрөг болж 122.8 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 227.2 сая төгрөг болж 5.8 сая төгрөгөөр буурсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага буурсанаас шалтгаалжээ.

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, 14.4.1 дэх хэсэгт заасныг зөрчин Татварын хэлтэстэй тооцоо нийлсэн актаар 498.2 мянган төгрөгийн өглөгтэй байсан нь санхүүгийн анхан шатны баримтаар дэмжигдээгүй тул 244.0 мянган төгрөгийн өглөг, 3.7 мянган төгрөгийн авлагыг дутуу бүртгэж тайлагнасныг залрууллаа.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 291.2 сая төгрөг болж 65.7 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,381.2 сая төгрөг болж 2,345.7 сая төгрөгөөр өссөн нь ЭМТ-д бусад бэлтгэсэн хөрөнгө, ЗДТГ-т 1,462.0 сая төгрөгийн зам гүүрийн барилга байгууламж, ЕБС-д 949.0 сая төгрөгийн барилга байгууламж нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дэх хэсэгт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчин Торхилгийн голын гүүр 1,444,049.8 мянга, Зүүн сайгийн гүүр 18,000.0 мянга, нийт 1,462,049.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,075.1 сая төгрөг болж 2,559.6 сая төгрөгөөр өссөн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,041.1 сая төгрөгөөр буюу 21.8 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 468.8 сая төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.5.5 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 84.9 сая, татварын бус орлого 82.3 сая, тусламж санхүүжилтийн орлого 2,859.0 сая, нийт 3,026.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Давст сумын ИТХ:

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Сумын олон нийтийн цагдаагийн ажилтанд 1,270.0 мянган төгрөгийн дүрэмт хувцас олгож төрд хохирол учруулсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1,274.0 мянган төгрөгийн бензин шатахууны зардал гаргахдаа хийсэн ажлын тайлан хавсаргаагүй, замын хуудас хөтөлсөн боловч ямар ажлаар явсан нь тодорхой бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө

Давст сумын Эрүүл мэндийн төв:

-Давст сумын Эрүүл мэндийн төв нь Давст сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дүгээр тушаалыг зөрчин Ковид-19 цар тахалтай холбогдуулан олгосон санхүүжилтээс ажилтнуудад 28,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 268/А67 дугаар хамтарсан тушаалын 3.7 дахь хэсэгт “Энэхүү журмын 3.1-3.5-д заасан санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, эм, урвалж бодисын зэрэг шууд зардал болон холбогдох бусад шууд бус зардал багтана” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

Давст сумын Соёлын төв

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин 78.0 мянган төгрөгийн урсгал зардлыг шууд зардалд бүртгэж тайлагнасныг залруулаа.

Давст сумын Ерөнхий боловсролын сургууль

-Аудитаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилт, бараа үйлчилгээний бусад зардал, шуудан холбоо, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг шууд зардалд бүртгэсэн 5,805.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулаа.

Давст сумын Засаг даргын тамгын газар

-Нягтлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчин тооцоо үүсгэхгүйгээр 2,069.9 мянган төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Давст сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/13 дугаар тогтоолоор 1,977.8 сая төгрөгөөр баталж 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/11 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 38.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,016.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,016.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1,261.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 682.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 11.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 61.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,251.8 сая, орон нутгийн төсвөөс 667.0 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 9.2 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 78.5 сая төгрөг, нийт 2,006.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,933.4 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 25.4 сая төгрөг, улсын төсөвт 9.7 сая төгрөг, нийт 35.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,933.4 сая төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь зардлыг 83.3 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Давст сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай А/11 дүгээр тогтоолд зааснаар Давст сумын Засаг дарга тайлант онд 30.1 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 88.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 295 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1.2 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 29.1 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 221.9 сая, нийт 252.3 төгрөгийн орлогыг бүрдүүлж 251.3 сая төгрөгийг зарцуулж 0.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Давст сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа хоцроож 5 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар үүссэн хөрөнгийг дансны бүртгэлд зөрүүтэй тусгаж байгааг анхаарах, Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлагын дансны бүртгэлийг анхаарч үзэх хэрэгтэй байна.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Давст сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 1,500.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,470.2 сая төгрөгийн 6 зөрчилд залрууллага хийж, 1.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.3 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 28.0 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	2	2.6			1	1.3	1	1.3		
2	ЭМТ	1	28.0							1	28.0
3	Соёлын төв	3	0,325.0	3	0,325.0						
4	ЕБС	1	5.8	1	5.8						
5	ЗДТГ	2	1,464.1	2	1,464.1						
Дүн		9	1,500.8	6	1,470.2	1	1.3	1	1.3	1	28.0

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.2 сая төгрөгийн алдааг залруулж, 7.6 сая төгрөгийн албан шаардлага, 1.1 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин 3.2 сая төгрөгийн анхан шатны баримтаар дэмжигдээгүй гүйлгээг санхүүгийн тайланд тусгаж тайлагнасныг залрууллаа.

4.2 Албан шаардлага

Аудитаар Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа 7.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн зөрчилд албан шаардлага өглөө.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

1.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчин 1.1 сая төгрөгийн зээл гараагүй үеийн хүүгийн авлагыг анхан шатны баримтгүйгээр бүртгэсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэхь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах

5.Аудитаар илэрсэн алдаа , зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэгтгэсэн тайлан	3	11.9	1	3.2			1	7.6	1	1.1
	НИЙТ	3	11.9	1	3.2			1	7.6	1	1.1

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/
 АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /Б.ЭНХМАНДАЛ/

2022 оны 03 сарын 22-ны өдөр